МЭДЭЭ · 2022 оны 11-р сарын 9

10 ДУГААР САРД ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ БУУРЧЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ
/2022.10.01-2022.11.01/

Нийт зөрчил 205.588 12%

Нийслэлд 151.130

Орон нутагт 54.458

Цагдаа 203.236

Мэргэжлийн хяналт 290

Онцгой байдал 32

Бусад 2030

Зөрчлийн улмаас учирсан хохирол 13.336.898.000 төгрөг

Төлөгдсөн хохирол 926.331.000 төгрөг

Шийтгүүлсэн хүн 204.149

Хуулийн этгээд 286

158.939

45210

16-18 нас 415

18-25 нас 26357

26-35 нас 73016

36-45 нас 59003

46-55 нас 30406

56-аас дээш нас 13633

Өссөн зөрчил

Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	11477
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	677
Оршин суугчдын амгалан тайван байдлыг	272
Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	99
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих	87
Хулгайлах	65

Буурсан зөрчил

Хүний биед халдах	1548
Мөрийтэй тоглоом тоглох	9
Өрсөлдөөний тухай хууль зөрчих	3
Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих	1
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	176.072

prokuror.mn

Улсын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын байдлаар 205588 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь 9 дүгээр сартай харьцуулахад 12 хувиар буурчээ.

Нийт зөрчлийн хэргийн 74 хувь нь Нийслэлд, 26 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бол 99 хувийг Цагдаагийн байгууллага, 0.14 хувийг Мэргэжлийн хяналт, 0.01 хувийг Онцгой байдал, 0.98 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалгаж шийдвэрлэсэн байна.

Дээрх хугацаанд 204149 хүн, 286 хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгүүлсэн ба өмнөх сараас шийтгэл оногдуулсан хүн 11.8 хувиар, хуулийн этгээд 6.3 хувиар тус тус буурчээ.

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 77.3 хувь нь эрэгтэй, 22 хувь нь эмэгтэй байгаа бол 64.2 хувь нь 26-45 насныхан байна.

Өнгөрсөн 10 дугаар сард үйлдэгдсэн зөрчлийг 9 дүгээр сартай харьцуулахад зарим төрлийн зөрчил өссөн дүнтэй байна. Тодруулбал, Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 18.1 хувиар, Хулгайлах зөрчил 14 хувиар, Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил 11.2 хувиар, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 6.8 хувиар, Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах зөрчил 1.5 хувиар тус тус өсжээ.

Харин Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчил 80 хувиар, Өрсөлдөөний тухай хууль зөрчих зөрчил 50 хувиар, Мөрийтэй тоглоом тоглох зөрчил 43.8 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 13.6 хувиар, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 4.7 хувиар, Хүний биед халдах зөрчил 0.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=9lE_RvPpLMQ

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2008